

Бага эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

1.Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2.Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)

1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3.Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (А.)

Зөв, Зөв, Буруу (В.)

Зөв, Буруу, Буруу (С.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Ходоод, 12 хуруу гэдэсний үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Аюулхай орчим төөнөх, хорсох маягаар өвдөх

2. Өвдөлт арагшаа нуруулуу дамжих

3. Өвдөлт хооллолттой холбоотой сэдрэх

4. Өвдөлт баруун мөр, гар руу дамжих

5. Өвдөлт доошоо цавь, хярзан руу дамжих

/2./ Макролидын бүлгийн антибиотیکیг сонгоно уу.

1. Клоксациллин

2. Тетрациклин

3. Эритромицин

4. Доксициклины гидрохлорид

5. Тробицин

/3./ Менингококцемн үед илрэх үндсэн хам шинжүүдийг дурьдна уу

1. Хордлогын хам шинж (халуурах, хоол, нойронд муудах)

2. Менингитын хам шинж (Брудзинскийн шинжүүд эерэг болох)

3. Энцефалитын хам шинж (ухаан балартах, солиорох)

4. Цусан тууралтын хам шинж (улаан гүвдрүүт тууралт, цусан тууралттай хавсран илэрч болно)

5. Хамар залгиурын үрэвслийн хам шинж (залгиурын арын хана улайж, хөхлөгүүд тодорсон байна, нусгайна)

/4./ Шингэн алдалттай суулгалтын шинжүүдийг заа:

1. Тайван биш, цочромтгой, цангасан, ховдоглон уух

2. Нүд хонхойх

3. Арьсны хуниас удаан, 2 секундийн дотор арилах

4. Унтаарсан, ухаангүй

5. Ууж чадахгүй буюу уухдаа муудах

/5./ Тэмбүү өвчин эмэгтэйд ямар шинжүүдээр илэрч болох вэ?

1. Бэлэг эрхтний орчим шарх гарна

2. Цавины булчирхай томорно

3. Хэрвээ эмэгтэй жирэмсан бол зулбах, дутуу төрөх, амьгүй хүүхэд төрөх хүндрэл тохиолдоно

4. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах

5. Бэлэг эрхтэн их загатнах

/6./ Дутуу төрөлтөөс сэргийлэхийн тулд ямар зүйлийг анхаарах ёстой вэ?

1. Зөв хооллож, ядрахгүй, хоногт 8-аас доошгүй цаг унтах, сэтгэл санаагаар тайван байх. Зөвхөн эмчийн зааврын дагуу эмийг хэрэглэх
2. Жирэмсний хожуу үеийн хордлогоос сэргийлэх
3. . Бэлгийн харьцааг цөөлөх, ялангуяа эхний 3 сар, сүүлийн 1 сард хориглох
4. Цэвэр, тохиромжтой, ялангуяа цээж, хэвлий бариагүй хувцас өмсөх. Өндөр өсгийтэй гутал өмсөхгүй байх
5. Жирэмсэн үед шөнийн жижүүр, хүнд хөдөлмөр, зогсоо ажил, доргио, халах, хөрөх, хими, туяаны нөхцөл, дуу шуугиан ихтэй ажил хийхгүй байх.

/7./ “Хүндрэлтэй үр хөндөлт, зулбалт” гэдэг ангилалтай эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Тохирох антибиотикийг булчинд, судсанд тарина.
2. Парацетамол өгч өдвөлтийг намдаана
3. Судсаар дусал хийнэ. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
4. Гэрт нь хариулна, 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
5. Умайд иллэг хийнэ.

/8./ Зүрхний шигдээсийн үед ямар арга хэмжээ авах вэ?

1. Хэвтрийн хатуу дэглэм сахиулах
2. Өвчин намдаах эмчилгээ
3. Хүчилтөрөгч эмчилгээ
4. Гепарин эмчилгээ
5. Аспирин

/9./ “Хэсэг газрын нянгийн халдвар” гэж ангилагдсан нярайд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Үүсгэгчийн эсрэг тохирох эмийг гэрээр уулгана
2. Хэсэг газрын халдварыг эмчлэхийг эхэд зааж сургана
3. 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
4. Антибиотикийн эхний тунг булчинд тарина
5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/10./ Хүүхдэд цээж хонхолзох шинжийг тодорхойлох зөв хариултуудыг сонго.

1. Амьсгал гаргах үед цээжний доод хэсэг дотогш татагдах
2. Амьсгал авах үед цээжний доод хэсэг дотогш татагдах
3. Зөвхөн хөхөө хөхөх, уйлах үед цээжний доод хэсэг дотогш татагдах
4. Тайван үед тогтмол ажиглагдана
5. Амьсгал авахад эгэмний хонхор татагдана

/11./ Умайн базлалтыг сулруулах /токолитик/ эмийн бодисуудыг нэрлэнэ үү

1. Магний сульфат
2. Ритодрин
3. Партусистен
4. Гинипрал
5. Папаверин гидрохлорид

/12./ Балнад өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хэвлийгээр өвдөнө, суулгана
2. Цөөн тооны ягаан тууралт хэвлий дээр гарна
3. Халууралт өдөр бүр ихсэж, ухаан балартах, солиорох, дэмийрэх шинж илрэнэ.
4. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шаталж гарна.
5. Гүйлсэн булчирхай улайж, хөөнгөтөж, идээлсэн байна

/13./ Артерийн даралтыг хэний аргаар хэмждэг вэ?

1. Франкын арга
2. Риво-Роччийн арга
3. Кочергений арга
4. Коротковын арга
5. Клемансын арга

/14./ Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйлчлүүлэгчдэд зонхилон тохиолддог сэтгэцийн эмгэгүүд:

1. Сэтгэл гутрал
 2. Сэтгэл түгших эмгэгүүд
 3. Архи хэрэглэх эмгэгүүд
 4. Нойрны хямарлууд
 5. Архаг ядаргаа
- /15./ Ходоод 12 хуруу гэдэсний шархлаат өвчний хүндрэлийг нэрлэнэ үү?
1. Цус алдах
 2. Ходоод цоорох
 3. Ходоодны гарах хэсэг нарийсах
 4. Тромбоэмболизм
 5. Өтгөн хатах
- /16./ Жирэмсний магадгүй шинжүүд юу вэ?
1. Биений юм хоригдох
 2. Үтрээ болон умайн хүзүүний салст хөхрөх
 3. Хэвлийн цагаан шугам, хөхний толгой нөсөөтөх
 4. Ургийн хэсэг тэмтрэгдэх
 5. Огиулж бөөлжих
- /17./ Сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгийг нэрлэнэ үү.
1. 3 долоо хоногоос дээш хугацаагаар ханиах
 2. Цустай цэр гаргах
 3. Цээжээр өвдөх
 4. Халуурах
 5. Турах
- /18./ Хэвлийгээр өвдөх шинж ямар өвчин эмгэгийн үед илрэх вэ?
1. Аюулхай орчим өвдөх нь гол төлөв ходоод, 12 хуруу гэдэс, өрц, улаан хоолойн доод хэсгийн өвчин байж болно
 2. Баруун талын хавирганы нумын доогуур өвдөх нь элэг, цесний хүүдий, цесний гол цорго, нойр булчирхайн толгой хэсэг, 12 хуруу гэдэс, баруун бөөрний өвчин байж болзошгүй.
 3. Хэвлийн баруун доод хэсгээр өвдөх нь мухар олгойн үрэвсэл, цутгалан гэдэсний үрэвсэл, баруун өндгөвч, шээлэйн өвчин, цавины ивэрхий зэрэг байж болзошгүй.
 4. Хэвлийн зүүн доод хэсгийн өвдөлт нь тахир гэдэс, зүүн талын өндгөвч, шээлэйн өвчин, цавины ивэрхий зэрэг байж болзошгүй
 5. Хүйсний орчим өвдөх нь нарийн гэдэс, чацархайн судас, булчирхай, сэмж, мэдэрлийн наран сүлжээ зэргийн өвчин байж болзошгүй
- /19./ Бруцеллёзыг ямар өвчинтэй ялган оношлогоо хийх ёстой вэ?
1. Балнад
 2. Хумхаа
 3. Лимфогрануломатоз
 4. Сүрьеэ
 5. Хэрх өвчин
- /20./ Шингэн алдалтгүй суулгалттай 1 настай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Гэрт нь А төлөвлөгөөний дагуу эмчлэнэ
 2. Суулгалт бүрийн дараа 50-100 мл шингэн уулгана.
 3. Хэзээ яаралтай үзүүлэхийг эхэд нь хэлээд, 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
 4. Суулгалт бүрийн дараа 200 мл шингэн уулгана.
 5. 4 цагийн турш 1 литр хорсол уулгана.
- /21./ Мөөгөнцөрийн халдвар ямар шинжээр илэрдэг вэ?
1. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
 2. Антибиотик хэрэглэсэн
 3. Бэлэг эрхтэн их загатнах
 4. Мөөгөнцрийн эсрэг эм хэрэглээгүй
 5. Хавьтагч шээхэд хорсож байсан
- /22./ Дутуу төрөхөд юу нөлөөлж болох вэ?

1. Жирэмсний хожуу үеийн хордлого
2. Жирэмсэн үедээ өвчин тусах
3. Жирэмсэн үедээ хүнд хүчир ажил хийх, ядрах, сэтгэл санааны таагүй байдал
4. Урьд өмнө зулбадаг, дутуу төрдөг байсан, өмнөх жирэмслэлт ба төрөх үеийн эмгэгүүд, олон удаа аборт хийлгэх

5. Бэлгийн замын халдварууд

/23./ Өвчтөн биохимийн ямар өөрчлөлтөөс болж амьсгаадаж болох вэ?

1. Уреми
2. Чихрийн шижингийн ком
3. Ацидоз
4. Гипербилирубинеми
5. Гипогликеми

/24./ “Завдсан зулбалт” гэдэг ангилалтай эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Тохирох антибиотикийг булчинд, судсанд тарина
2. 4-6 цаг ажиглаад цус алдалт багасахгүй бол эмнэлэгт шилжүүлнэ.
3. Судсаар дусал хийнэ.
4. Цус алдалт намдвал гэрт нь хариулна, 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
5. Умайд иллэг хийнэ

/25./ Төмөр дутагдлын цус багадалтын шалтгааныг заана уу?

1. Ойр ойрхон жирэмслэх
2. Цус алдах, сарын тэмдэг их хэмжээгээр ирэх
3. Архаг голомтот идээт үрэвсэл
4. Биед төмөр хангалтгүй хэмжээгээр орох
5. Ходоод, гэдэсний хагалгаа хийлгэсний дараа

/26./ “Нянгийн хүнд халдвар байж болзошгүй” гэж ангилагдсан нярайд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатайг эхэд нь тайлбарлана
2. Антибиотикийн эхний тунг булчинд тарина
3. Цусны чихэр багасахаас сэргийлнэ
4. Замдаа хүүхдээ дулаан авч явахыг зөвлөнө
5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/27./ Хяхтнаа амьсгал илэрсэн хүүхдэд бага эмч хэрхэн туслах вэ?

1. Гараа эмчилгээнд үүсгэгчийн эсрэг эмийн эхний тун, сальбутамол тохирох тунгаар уулгана
2. Гараа эмчилгээнд цусны сахар багасахаас сэргийлнэ
3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
4. Утлага хийж гэрээр эмчлэнэ
5. Хөлийг гичтэй усанд дүрж гэрээр эмчилнэ

/28./ Бэлгэвч хэрэглэх ашигтай тал юу вэ?

1. Бэлгийн замын халдвараас хамгаална
2. Аль ч насны эмэгтэйд тохиромжтой
3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй
4. Жирэмсэн үед мөн төрөлт, зулбалт, үр хөндөлтийн дараа шууд хэрэглэх боломжтой
5. Хүссэн үедээ хэрэглэх, зогсоох боломжтой

/29./ 20 долоо хоногтой жирэмсэн эхийн үзлэг хийх зорилго нь юу вэ?

1. Жирэмсний хугацааг тодорхойлох
2. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
3. Жирэмснийг тээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэх.
4. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
5. Төрөх газрыг товлох

/30./ Улаанууд өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Жижиг зангилаат улаан тууралт нуруу, өгзөг, биеийн арын хэсгээр шигүүрэх хандлагатай биеэр гарна
2. Халууралт ба тууралт нь нэгээс хоёр хоногийн дотор ямар ч эмчилгээгүй арилна

3. Дагзны буюу хүзүүний арын булчирхай томрох хандлагатай
4. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шаталж гарна
5. Жижиг зангилаат тууралт бүх биеэр гарна, биеийн дотор буюу хэвлийн доод хэсгээр шигүүрэх хандлагатай, ам, хамрын гурвалжин цэвэр байна

/31./ Бумба тавих заалтыг тодорхойлно уу

1. Гуурсан хоолойн үрэвсэл
2. Уушигны үрэвсэл
3. Хавирга хоорондын үрэвсэл
4. Нуруу цээжний өвдөлт
5. Уушигны сүрьеэгийн идэвхитэй хэлбэрийн үед

/32./ Уушгины үрэвслийн үед илрэх гол шинж юу вэ?

1. Ханиалгах
2. Халуурах
3. Цустай цэр гарах
4. Цээжээр өвдөх
5. Хөхрөх

/33./ Бүх биеийг угаахгүй ямар тохиолдол байдаг вэ?

1. Арьсны хурц эмгэг өвчний үед
2. Хурц халдварт өвчнөөр өвчилсөн үед
3. Мэдрэл, сэтгэцийн хурц эмгэгшлийн үед
4. Биеийн байдал хүндэвтэр үед
5. Босч чаддаггүй хүнд өвчтөнд

/34./ Жирэмсний эрт үеийн хордлого ямар шинжүүдээр илэрдэг вэ?

1. Огиулж бөөлжих
2. Хоолонд дургүй болох
3. Үнэрлэх, амтлах мэдрэхүй өөрчлөгдөх
4. Даралт ихсэх
5. Хавагнах

/35./ Цус алдах үед бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Цусыг тогтоох физик, механик, биологийн аргуудаас боломжтойг нь ашиглах
2. Цусны бүлэгнэлтийг дэмжих Кальцийн бэлдмэл, викасол, аминакапроны хүчил зэрэг эмчилгээг хийнэ
3. Хаанаас алдаж байгаагаас хамааран хүйтэн жин тавих, мөс залгиулах, чангалуур, чихээс тавих зэрэг аргуудыг хэрэглэнэ
4. Өвчтөн ба гэр бүлийн гишүүдийг тайвшруулна
5. Цус алдалт зогсохгүй бол өвчтөнийг эмнэлэгт яаралтай хүргэж өгнө

/36./ Элэг хамгаалах бэлдмэлүүдийг нэрлэнэ үү.

1. Имодиум
2. Легалон
3. Денол
4. Эссенциал
5. Катерген

/37./ Бруцеллёзоос урьдчилан сэргийлэхийн тулд бага эмч ямар арга хэмжээ авах вэ?

1. Мал, амьтадтай ажилладаг хүмүүс хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийг өмсөх талаар зөвлөх
2. Мах, сүү, цагаан идээг сайн боловсруулж хэрэглэхийг зөвлөх
3. Шинжилгээ хийлгээгүй малын сүү, өрөм, тос, мах худалдан авах ба хэрэглэхээс болгоомжлохыг зөвлөх
4. Донорын цусанд шинжилгээ хийлгэхийг зөвлөнө
5. Амьсгал дуслын замаар халдварладаг тул амны хаалт хийхийг зөвлөнө

/38./ 2 настай хүүхэд ханиалгасан, амьсгал нь 1 минутанд 52 болсон ба цээж нь хонхолзож байсан. Өөр эмгэг шинжгүй. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?

1. Амьсгал олшроогүй

2. Амьсгал олширсон
 3. "Ханиад шуухнаа" гэж ангилна
 4. "Уушгины хүнд хатгалгаа" гэж ангилна.
 5. "Уушгины хатгалгаа" гэж ангилна
- /39./ Заг хүйтний эмчилгээнд юуг хэрэглэх вэ?
1. Бензатилпенициллин G 2,6 саяаар тарина
 2. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух
 3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух.
 4. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих
 5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух.
- /40./ Доод мөчний аль нэгэнд хаван үүсэх нь ямар шалтгаантай байж болох вэ?
1. Хэвлийн ба аарцгийн хөндийн хавдар өрөөсөн хөлний хураагуур судас дарах
 2. Төрлөг ба хэвлийн хөндийн томоохон хагалгааны дараа хураагуур судсанд бөглөрөлт үүсэх
 3. Удаан зогсдог ажилтай хүний доод мөчний хураагуур судас өргөссөнөөс хавагнах
 4. Зүрхний дутагдал
 5. Бөөрний дутагдал
- /41./ "Завдсан зулбалт" гэдэг ангиллыг ямар шинжүүдийг үндэслэн тавьдаг вэ?
1. Үтрээнээс цус гарах ба үтрээний ялгадас эвгүй үнэртэй байх
 2. Үтрээнээс цус гарах ба умайд ажилбар хийж зулбуулсан.
 3. Үтрээнээс цус гарах ба хэвлийгээр өвдөх.
 4. Үтрээнээс бага зэрэг цус гарах
 5. Үтрээнээс цус гарах ба 38 хэмээс дээш халуурах
- /42./ Чихрийн шижингийн шалтгаан аль нь вэ?
1. Таргалалт
 2. Удамшил
 3. Хоол хүнсний хэрэглээ
 4. Архаг идээт голомтот үрэвсэл
 5. Тархины гэмтэл
- /43./ "Нянгийн хүнд халдвар байж болзошгүй" гэж ангилагдсан нярайд пенициллин, гентамициныг ямар тунгаар тарих вэ?
1. Гентомициныг 5 мг\кг
 2. Гентомициныг 2,5 мг\кг
 3. Пенициллиныг 100000 нэгж\кг
 4. Пенициллиныг 50000 нэгж\кг
 5. Нярайд эдгээр антибиотикийг тарихгүй
- /44./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Тамхи татдаг эмэгтэй
 3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
 4. Зүрхний цус хомсдох эмгэгтэй
 5. Цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй
- /45./ 12 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд анхны үзлэгээр ямар шинжилгээ хийх ёстой вэ?
1. Цус, шээсний ерөнхий шинжилгээ
 2. Чанд авианы шинжилгээ
 3. Үтрээний наацын шинжилгээ
 4. Тэмбүү, ХДХВ-ийн шинжилгээ
 5. Флюорографи
- /46./ Улаан эсэргэн өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Жижиг зангилаат тууралт бүх биеэр гарна, хэвлийн доод хэсгээр шигүүрэх хандлагатай, ам, хамрын гурвалжин цэвэр байна.

2. Хоолой тод заагтай улайж үрэвсэнэ

3. Эрүүн доорхи буюу хүзүүний урд талын тунгалгийн булчирхай томорч цочирно

4. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шатлаж гарна

5. Ханиах, нус гойжих, нүд улайх шинжийн аль нэг илэрч болно

/47./ Хүйтэн жин ямар үйлчилгээ үзүүлэх вэ?

1. Хэсэг газрыг хөргөж цусны судсыг нарийсгана.

2. Мэдрэлийн төгсгөлийн мэдрэх чадварыг бууруулна.

3. Өвчин намдаана

4. Халуун бууруулна

5. Цусан хангамжийг багасгана.

/48./ Сэтгэл түгших эмгэгтэй өвчтөнд бага эмчийн зүгээс өгөх зөвлөмжүүд:

1. Стресс тайлах ур чадварыг эзэмших зөвлөгөө өгнө

2. Сэтгэл түгших эмгэг бол эмчлэгдэх боломжтой өвчин гэдгийг ойлгуулна

3. Зүрх дэлсэх, амьсгал давчих зэрэг биеийн шинжүүдэд анхаарлаа төвлөрүүлэхгүй байх, учир нь айдас, түгшэлтийг улам ихэсгэдэг гэдгийг ойлгуулах

4. Өөрийгөө тайвшруулан удирдах ба амьсгалын дасгал хийж сурах

5. Сэтгэл түгшилт, айдасыг даван туулахын тулд архи хэрэглэхээс зайлсхийх

/49./ “Хүнд хүндрэл бүхий улаанбурханыг” ямар шинжүүдээр ангилах вэ?

1. Татах

2. Нүдний эвэрлэг бүдгэрэх

3. Амны гүнзгий өргөн шархлаа

4. Амьсгал олшрох

5. Суулгах

/50./ Ямар эмгэгүүд шээс цочмог хаагдахад хүргэдэг вэ?

1. Түрүү булчирхайн хавдар

2. Бөөрний дутмагшил

3. Шээсний хос суваг дарагдах

4. Хэвлийн хөндийн хагалгааны дараа

5. Ерөнхий унтуулгатай мэс заслын дараа

/51./ Жирэмсэн эмэгтэй нийгмийн зүгээс ямар халамжийг авах эртэй вэ?

1. Жирэмсэн эмэгтэй хүнд хүчир ажил, шөнийн ээлжний ажлаас чөлөөлөгдөх эрхтэй.

2. Хүүхдийн тоог, төрөлт хоорондын зайг өөрсдөө шийдвэрлэх эрхтэй

3. Нэн ядуу, ядуу амьдралтай гэр бүлийн эх жирэмсний 5 сартайгаас эхлэн сар бүр 20000 төгрөг тогтмол авах эрхтэй

4. Жирэмсэн эмэгтэй бүр сар бүр 50000 төгрөгний тэтгэмж авах эрхтэй

5. Төрүүлсэн эх бүр сар бүр 50000 төгрөгний тэтгэмж авах эрхтэй

/52./ Хамраас цус гоожих шалтгаан:

1. Гэмтэл

2. Артерийн даралт ихсэх

3. Тромбоцитопени

4. Хамрын хавдар буюу ур

5. Гемофили

/53./ Цээжээр өвдөх шинжтэй өвчтөнд бага эмч ямар менежмент хийж, хэрхэн туслах вэ?

1. Өвдөлтийн шалтгааныг яаралтай тогтооно

2. Зүрхний шалтгаанд өвдөлт гэж үзвэл нитроглицерин, валидол, аналгин хэрэглээд, өвчтөнийг тайвшруулаад 15 минут ажиглана. Өвдөлт намдахгүй бол эмнэлэгт хэвтүүлэх

3. Хавирганы мэдэрлийн үрэвсэл, хавирга гэмтсэн үед өвдөлт намдаах эм хэрэглэх, гич наах, өвдөлт намдаах тууз наах, бумба, бэгнүүр тавих. Уушгины эмгэгээс шалтгаалж цээж өвдөж байвал гэрэлд харуулах, үүсгэгчийн эсрэг эм хэрэглэх, дотрын эмчид үзүүлж заалтыг биелүүлэх

4. Зүрхний шигдээс өвдөлтийн шалтгаан гэж үзвэл нитроглицерин, аналгин, димедрол тариад гэрээр эмчлэх.

5. Зүрхний бах цээжний өвдөлтийн шалтгаан гэж үзвэл эмнэлэгт яаралтай хэвтүүлэх.
- /54./ Зүрхний бахын өвчин хөдлөлийн үед ямар эм хэрэглэх вэ?
1. Нитронг
 2. Валидол
 3. Дипридамол
 4. Глицерилтринитрат
 5. Дигоксин
- /55./ Татрангийн халдварыг ямар замаар авч болох вэ?
1. Ямар нэг шарх, хатиг бохирлогдоход
 2. Түлэгдэлт, хөлдөлтийн шархаар
 3. Хууль бус үр хөндөлтийн явцад
 4. Хэвтрийн холголт, цооролтоор
 5. Хавдрын ургац задарч шарх болж, түүнд халдвар орсон тохиолдолд
- /56./ 3 настай хүүхэд ханиалгаж байгаа ба түүний амьсгал 1 минутанд 48 байна. Өөр эмгэг шинжгүй. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?
1. Амьсгал олшроогүй
 2. Амьсгал олширсон
 3. "Ханиад шуухнаа" гэж ангилна
 4. "Уушгины хатгалгаа" гэж ангилна
 5. "Уушгины хүнд хатгалгаа" гэж ангилна
- /57./ Трихомоназын эмчилгээнд юуг хэрэглэх вэ?
1. Бензатилпенициллин G 2,6 саяаар тарина
 2. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух
 3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух.
 4. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух
 5. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих
- /58./ Жирэмсэн эх жирэмсний хожуу хордлогоос сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авахыг эхэд зөвлөх вэ?
1. Уух шингэнийг хоногт 700-800 мл хүртэл хязгаарлах
 2. Давсны хэмжээг 3-5 гр хүртэл хязгаарлах
 3. Цагаан идээ, ургамлын гаралтай аминдэмээр баялаг хоол идэх . Долоо хоногт 1 өдөр цагаан хоол эсвэл 1-1,5 кг алим идэх
 4. Биеийн жингээ тогтмол үзүүлж, эмгэг нэмэгдэл байгаа эсэхийг тогтоолгох
 5. Артерийн даралтаа хэмжүүлж байх. Хөлөнд хаван үүсч буй эсэхийг ажиглаж байх.
- Шээсний шинжилгээ өгөх
- /59./ Квинкийн хаван ямар онцлогтой вэ?
1. Хаван зөвхөн дээд мөчний нэг талд илрэх
 2. Гэнэт нүүр, уруул, зовхи, хэл мэдэгдэхүйц хавагнах
 3. Шээс ховордох
 4. Хаван харшлын эсрэг эмчилгээнд хурдан бүр мөсөн арилна
 5. Хаван зөвхөн доод мөчний нэг талд илрэх
- /60./ Ампициллин, Гентомицин, Метронидазол зэрэг Зантибиотикийг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Хэвлийгээр хүчтэй өвдөх эсвэл маш хүнд халууралт өвчнүүд
 2. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт
 3. Умайн болон ургийн халдвар
 4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан
 5. Шээсний дээд замын өвчин
- /61./ Гуурсан хоолойн үрэвслийн үед ямар эмчилгээ хийх вэ?
1. Үрэвслийн эсрэг

2. Гуурсан хоолойн агчилтыг тавиулах
3. Цэр ховхлох, шингэлэх эмийн эмчилгээ
4. Гуурсан хоолойг өргөсгөх
5. Утлага

/62./ Хөхөө зөв үмхэсний шинжийг нэрлэнэ үү?

1. Эрүү хөхөнд хүрсэн
2. Амаа том ангайсан
3. Доод уруул цорвойсон
4. Хөхний нөсөөт хэсэг амны дээр илүү харагдсан.
5. Доод уруул дотогш эргэсэн

/63./ Хүүхдийн түвэнхийн үрэвсэл, нарийсал хэрхэн хүндрэх аюултай вэ?

1. Хоолой боогдож бачуурах
2. Хүчилтөрөгчийн дутагдлаас тархи хавагнаж, татах
3. Уушгины хатгаагаар хүндрэх
4. Уушги хийжих
5. Гялтангийн хөндийд шингэн хуримтлагдах

/64./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн сул тал юу вэ?

1. Дотор эвгүүрхэх, толгой өвдөх гаж нөлөө илэрч болно
2. Хөхөөр хөндүүрлэж болно
3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно
4. Эмийг өдөр бүр уух нь төвөгтэй
5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй

/65./ ЭМСайдын тушаалын дагуу анхны үзлэгээр өвчтэй нь тогтоогдсон жирэмсэн эмэгтэйг хэн хянах ёстой вэ?

1. Эх барих эмэгтэйчүүдийн эмч
2. Сумын эмч
3. Нарийн мэргэжлийн эмч тухайн өвчнөөс нь хамааран
4. Багийн бага эмч
5. ЭНЭШТ-ийн эмч

/66./ Улаан бурхан өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шаталж гарна
2. Ханиах, нус гойжих, нүд улайх шинжийн аль нэг илэрч болно
3. Амны салст улайж, жижиг цагаан толбон тууралт гарна
4. Цэврүүн тууралт арьс, салст, биеийн үсэрхэг хэсгээр гарна
5. Жижиг зангилаат тууралт бүх биеэр гарна, хэвлийн доод хэсгээр шигүүрэх хандлагатай, ам, хамрын гурвалжин цэвэр байна

/67./ Сэтгэл түгших үед өвчтөнд илэрч болох шинжүүд:

1. Зүрх дэлсэх, судасны цохилд олшрох, артерийн даралт ихсэх
2. Амьсгал олшрох, амьсгаа давчдах, цээжин дээр хүнд юм дарах мэт санагдах
3. Ходоод орчим өвдөх, агших нь мэдэгдэх, юм залгахад түвэгтэй мэт санагдах
4. Шээс ойр ойрхон хүрэх
5. Нойр хульжих

/68./ Шээлгүүр тавих зорилгыг тодорхойлно уу?

1. Давсаг угаах
2. Давсган дахь шээсийг авах
3. Давсганд эмийн бодис хийх
4. Давсаг дурандахын өмнө
5. Давсганд мэс засал хийхийн өмнө

/69./ Жирэмсэн эмэгтэйд жирэмслэлт, төрөлттэй холбоотой хууль зүйн ямар ойлголт өгөх вэ?

1. Хүн бүр нөхөн үржихүйн амьдралыг чөлөөтэй хянаж, таашаал авч байх эрхтэй ба албадан жирэмслэлт, үрийн суваг боолгох, үр хөндөлтөөс чөлөөтэй байх эрхтэй
2. Ямар ч эмэгтэй хүн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, энэ талаар мэдээлэл авч, боловсрол эзэмшиж, жирэмслэлтээ өөрөө зохицуулах эрхтэй

3. Эмэгтэй хүн бүр жирэмсэн буюу хүүхэд төрүүлсний улмаас нийгэм, ахуй, ажил эрхлэлтийн хүрээнд халамж үйлчилгээ авах эрхтэй ба ялгаварлан гадуурхагдах ёсгүй

4. Эмэгтэйчүүд шашин, ёс заншлаас ангид байж өөрийн бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралын талаар чөлөөт сонголт хийх эрхтэй

5. Хүн бүр гэрлэх, гал голомтоо бий болгох, төлөвлөх эрхтэй

/70./ Бөөр, шээсний замаас цус алдах шалтгаан:

1. Бөөрний чулуу
2. Бөөрний хавдар
3. Бөөрний сүрьеэ
4. Бөөрний үрэвсэл
5. Бөөрний гэмтэл

/71./ Цээжээр өвдөх нь уушги, гялтангийн үрэвсэлтэй холбоотой байж болзошгүй бол ямар шинжүүдээр батлах вэ?

1. Амьсгалын хөдөлгөөнтэй холбоотой өвдөнө
2. Өвдөлт гүн ханиахад ихэснэ
3. Ханиах ба амьсгал олшрох, уушги чагнахад амьсгал сулрах, тогшиход авиа бүдгэрэх шинжүүд илрэх
4. Өдвөлт гүн амьсгалахад, найтаахад өвдөнө
5. Хөхийг тэмтрэхэд хөхний зангилаа хүчтэй өвдөх

/72./ Хоолой сөөсөн үед дараахи зүйлийг хориглоно. Үүнд:

1. Утлага хийх
2. Горчичник хэрэглэх
3. Эм уух
4. Чанга ярьж дуугарах
5. Бигнүүр тавих

/73./ Вируст гепатитаар өвчлөөд эдгэрсэн өвчтөнд нөхөн сэргээх шатанд нь бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Нэг жилийн турш хяналтанд байлгана
2. Алат, Асат, билирубины шинжилгээг 3–6 сар тутамд давтан үзнэ
3. Өөх тосгүй, шарж хуурайгүй, хурц амтлагчгүй хоол идэхийг зөвлөнө
4. Архи, пив, шоколад зэргийг хатуу хорино
5. Биеийн хүнд хүчир ажил, тэмцээнд оролцохгүй байх ба шөнө 8-аас доошгүй цаг, өдөр нэг цаг унтаж амарч байхыг зөвлөнө

/74./ 3 сартай хүүхэд ханиалгаж байгаа ба түүний амьсгал 1 минутанд 48 байна. Өөр эмгэг шинжгүй. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?

1. Амьсгал олширсон
2. Амьсгал олшроогүй
3. Уушгины хатгалгаа” гэж ангилна
4. "Ханиад шуухинаа" гэж ангилна
5. "Уушгины хүнд хатгалгаа” гэж ангилна

/75./ “Заг хүйтэн эсвэл хламидийн халдвар байж болзошгүй” гэсэн ангилал бүхий эмэгтэйд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Тохирох антибиотикийг эмэгтэйд уулгана
2. Тохирох антибиотикийг хавьтагчид уулгана
3. Бэлгэвчийг зөв, байнга хэрэглэх талаар зөвлөгөө өгнө
4. Дахин бэлгийн хавьталд орохгүй байхыг зөвлөнө
5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/76./ Жирэмсний хожуу үеийн хордлогын шинж илрэхэд эх яагад эмчид даруй үзүүлэх ёстой вэ?

1. Эхэс хавагнах, ураг бүтэх магадлал ихтэй
2. Эх манас таталтаар хүндрэх магадлал ихтэй
3. Эх амь насаа алдах аюултай
4. Төрөлхийн гажигтай хүүхэд төрөх магадлал өндөр
5. Хөлний хаван насан туршдаа тогтох магадлал өндөр

/77./ Бөөрний дутагдлаас үүсэх хаван ямар онцлогтой вэ?

1. Хаван зөвхөн дээд мөчний нэг талд илрэх
2. Шээс ховордох
3. Хаван өглөө багасах, орой ихсэх, хөлөөр илүүтэй гарах хандлагатай
4. Хаван өглөөгүүр нүүр, зовхиор илүүтэй гарч, орой багасах хандлагатай
5. Хаван зөвхөн доод мөчний нэг талд илрэх

/78./ Ампициллин, Гентомицин зэрэг 2 антибиотикийг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?

1. Маш хүнд халууралт өвчнүүд
2. Шээсний дээд замын өвчин эсвэл уушгины хатгаа
3. Умайн болон ургийн халдвар
4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан
5. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт

/79./ Бөөрний архаг дутагдлын үед илрэх шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Арьсны өнгө зөвхий саарал
2. Шээсний хувийн жин буурна
3. Цусанд креатинин ихсэнэ
4. Ханиалгаж цэр гарах
5. Гар хөл салгалж чичрэнэ

/80./ Төрөхөд вакцинуудаа хийлгээгүй 14 хоногтой хүүхдэд ямар вакцинуудыг нөхөн хийж болох вэ?

1. БЦЖ
2. Саа-1
3. ВГ-1
4. 5-т вакцин
5. СХХТ

/81./ Хүүхдийн түвэнхийн үрэвсэл, нарийсал ямар шинжүүдээр илэрдэг вэ?

1. Хяхтнаа амьсгал
2. Хоолой сөөх
3. Хуцуулах ханад
4. Шуугиант амьсгал
5. Хөхүүлэх ханиад

/82./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн ашигтай тал юу вэ?

1. Зөв хэрэглэсэн тохиолдолд 99% үр дүнтэй
2. Бэлгийн хавьталд нөлөө үзүүлэхгүй, саад учруулахгүй
3. Биений юмны мөчлөг тогмолжиж, бага хэмжээгээр, цөөн хоног, өвдөлтгүй ирдэг болно
4. Эмийг зогсооход жирэмслэх чадвар хурдан сэргэнэ
5. Умайн салстын болон өндгөвчний хорт хавдраас сэргийлнэ

/83./ ЭМСайдын тушаалаар 12 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр юу хийх ёстой вэ?

1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
2. Эх барихын тусгайлан үзлэг хийх
3. Нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх
4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тогтоох
5. Ургийн зүрхний цохилтыг сонсох

/84./ Менингит нь халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Ханиалгах, цэр гарах
2. Толгой хүчтэй өвдөх
3. Хэвлийн булчин чангарах
4. Дагзны булчин хөшингө болох
5. Шээс цустай гарах

/85./ Өвчтөн суулгалт өвчтэй, эдгээрээс хамгийн тохиромжтой сувилгааг сонгоно уу

1. Эмчийн заавраар эм өгөх

2. Анус орчмын арьс нурахаас сэргийлэх
3. Шингэн уулгах
4. Өвчтөнийг бие засахад нь туслах
5. Хоолны дэглэм баримтлуулах

/86./ Сэтгэл түгшилтийг ихэсгэдэг органик шалтгаанууд:

1. Дотор муухайрах буюу бөөлжих
2. Уураг тархины эмгэгүүд (тархины үрэвсэл, гэмтэл, хавдар)
3. Ухаан балартах
4. Амьсгалын дутагдалд хүргэдэг амьсгалын тогтолцооны эмгэгүүд
5. Хорт хавдарын гаралтай хүчтэй өвдөлт

/87./ “Маш хүнд халууралт өвчин” гэж ангилагдсан хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатайг эхэд нь ойлгуулна
2. Үүсгэгчийн эсрэг тохирох эмийн эхний тунг өгнө
3. Цусны сахар багасахаас сэргийлж эмчилнэ
4. 38,5 хэмээс дээш халуунтай бол парацетамол өгнө
5. Гараа эмчилгээ хийсний дараа эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/88./ Цэвэрлэх бургуй ямар механизмаар үйлчилдэг вэ?

1. Гэдэсний ханы мэдрэлийн төгсгөлийг цочрооно.
2. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг нэмэгдүүлнэ.
3. Өтгөнийг гадагшлуулах үйлчилгээ үзүүлнэ.
4. Гэдэсний ханы мэдрэлийн төгсгөлийн мэдрэх чадварыг бууруулна.
5. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг багасгана.

/89./ Зулбалтаас сэргийлэхийн тулд ямар зөвлөгөөг жирэмсэн эмэгтэйд бага эмч өгөх ёстой вэ?

1. Зөв хооллож, ядрахгүй, хоногт 8 цагаас доошгүй унтах, сэтгэл санаагаар тайван байх
2. Тамхи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх. Эмийг зөвхөн эмчийн зааврын дагуу хэрэглэх
3. Бэлгийн харьцааг цөөлөх, ялангуяа эхний 3 сар, сүүлийн 1 сард хориглох
4. Цэвэр, тохиромжтой, ялангуяа цээж, хэвлий бариагүй хувцас өмсөх. Өндөр өсгийтэй гутал өмсөхгүй байх

5. Жирэмсэн үед шөнийн жижүүр, хүнд хөдөлмөр, зогсоо ажил, доргио, халах, хөрөх, хими, туяаны нөхцөл, дуу шуугиан ихтэй ажил хийхгүй байх

/90./ Хоол боловсруулах замаас цус алдах шалтгаан:

1. Улаан хоолойн судасны өргөсөлт
2. Улаан хоолой, ходоод, гэдэсний шархлаа
3. Улаан хоолой, ходоод, гэдэсний хавдар
4. Шамбарам
5. Шулуун гэдэсний цууралт

/91./ Цээжээр өвдөх нь зүрхний бах, шигдээсийн шалтгаантай болохыг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Өдвөлт зүүн гар, мөр рүү дамжих
2. Цээж давчин, агаар дутагдах, айдас төрөх
3. Зүрхний хэмнэл алдагдах, цусны даралт хэлбэлзэх
4. Өдвөлт баруун гар, мөр рүү дамжих
5. Гүн амьсгалах, ханиах үед өвдөлт ихсэх

/92./ Энгийн хялбар аргаар нүдэнд боолт хийхэд шаардлагатай зүйлсийг нэрлэнэ үү?

1. Ариутгасан бинт, самбай
2. Хайч
3. Ариутгасан хөвөн
4. Наалт/лент/
5. Ариун бээлий

/93./ В вируст гепатитаас урьдчилан сэргийлэх зорилгоор бага эмч ямар арга хэмжээнүүдийг авсан байх ёстой вэ?

1. Нярайд 24-48 цагийн дотор, мөн 2,8 сартай хүүхдийг В гепатитын эсрэг өвөрмөц дархлаажуулалтанд хамруулна

2. Өвчлөгсдийг эрт илрүүлэх
3. Доноруудыг шинжлэх
4. Нэг удаагийн тариур, багаж хэрэгсэл ашиглах
5. Бээлий, хөдөлмөр хамгааллын хувцас ашиглах

/94./ 2 сараас 5 хүртэлх насны хүүхдэд ямар аюултай ерөнхий шинжийг бага эмч үзлэгийн явцад шалгах ёстой вэ?

1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу?
2. Уусан бүхнээ бөөлжиж байна уу?
3. Хүүхэд татсан уу? Ухаангүй байна уу?
4. Хүүхэд уух, хөхөхдөө муудсан уу?
5. Хүүхэд өндөр халуурч, тайван биш болсон уу?

/95./ “Заг хүйтэн эсвэл хламидийн халдвар байж болзошгүй” гэсэн ангилалыг ямар шинжийг үндэслэн тавих вэ?

1. Үтрээнээс идээрхэг, хэвийн бус ялгадас гарах
2. Хавьтагчийн шээсний сүвнээс идээ гарч байсан
3. Хавьтагч шээхэд хорсож байсан
4. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
5. Бэлэг эрхтэн дээр яр гарах

/96./ Сорил тарилгыг харшлыг илрүүлэх зорилгоор тавьдаг учир бугалганы 1/3 орчмын талбайг сонгодог яагаад гэвэл зарим тохиолдолд халдвараас сэргийлэх зорилгоор тавьдаг.

/97./ Биеийн халуун өглөө 9-11 цаг, оройн 16-18 цагийн хооронд багасаж, хэвийн байдалдаа ордог. Ердийн эрүүл насанд хүрсэн хүний халуун 37-38 хэм байдаг ба хүүхдийнх 35.5-36.5 байдаг.

/98./ Цэвэрлэх бургуйг тавихдаа үйлчлүүлэгчийг баруун хажуугаар нь хэвтүүлдэг яагаад гэвэл нэг удаад 5-6 литр крантны усаар тавьдаг учир дээрхи байрлал тохиромжтой байдаг.

/99./ Эмийн бодисыг тарилгаар хэрэглэхийн өмнө шалгахдаа эмийн түүвэртэй тулгах, тариурт соруулахын өмнө шалгах, тарилгыг хийсний дараа шалгах орно.

/100./ Арьс хэвийн бус цайж цонхийх нь хүнд хэлбэрийн цус багадалтын шинж тиймээс цус сэлбэх шаардлагатай учир зөвхөн цусны бүлгийг шалгасан байхад хангалттай

/101./ “Рахитгүй” гэж ангилагдсан хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн шахмалаас ямар тунгаар, хэдийд өгөх вэ?

- A. Нэг удаа 1 шахмал уулгана
- B. Даваа гариг бүрт 1 удаа 1 шахмалыг 1 сар өгнө
- C. 6,7,8,9-р саруудад урьдчилан сэргийлэх тунг уулгахгүй. Бусад саруудад 14 хоногтойгоос эхлээд 1 шахмалыг 2 нас хүртэл сар бүр уулгана.
- D. Рахитгүй тул Д аминдэм уулгахгүй
- E. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа 1 шахмалаар, нийт 7 удаа өгнө

/102./ Сар гаруй суулгасан, өчигдрөөс баасанд нь цус харагдсан, нүд нь хонхойсон, шингэн ховдоглон ууж буй, арьсны хуниас хэвийн арилж буй, ууртай, цочромтгой болсон 1 настай хүүхдэд ямар ангилал тавих вэ?

- A. Ужиг суулгалт
- B. Шингэн их алдалттай суулгалт
- C. Шингэн алдалтгүй суулгалт
- D. Шингэн алдалттай, хүнд ужиг, цусан суулгалт
- E. Дисбактериоз.

/103./ Туберкулины сорилын хариу урвалыг хэзээ хэмжиж тодорхойлох вэ?

- A. 72 цагийн дараа

- B. 48 цагийн дараа
 - C. 24 цагийн дараа
 - D. 2-3 долоо хоногийн дараа
 - E. Сорилыг даруй уншина
- /104./ Цустай суулгасан нярайг хаана, хэн эмчлэх вэ?
- A. Гэрт нь өрхийн эмч эмчилнэ
 - B. Эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ
 - C. Амбулатороор эмчилнэ
 - D. Амбулатороор шинжилгээ өгч, шаардлагтай бол эмнэлэгт хэвтүүлнэ.
 - E. Гэрт нь ээж нь эмчилнэ
- /105./ Гуурсан хоолойн салст бүрхэвчинд байрлах сормууст эс ямар үүрэгтэй вэ?
- A. Цэвэрлэх шүүх
 - B. Липопротейд ялгаруулах
 - C. Дулаан үүсгэх
 - D. Шүүрэл ялгаруулах
 - E. Нөхөн төлжилт хийх
- /106./ Зүрхний ишеми өвчинг үүсгэх гол шалтгаан юу вэ?
- A. Удамшил
 - B. Халдвар
 - C. Титэм судас хатуурах
 - D. Архаг халдварын голомт
 - E. Хөгшрөлт
- /107./ Гуурсан хоолойн архаг үрэвслийн үед дараах шинжүүдээс аль нь илрэх вэ?
- A. Байнга ханиалгах
 - B. Цээжээр өвдөх
 - C. Цустай ханиах
 - D. Амьсгаадах
 - E. Маш их цэртэй ханиах
- /108./ 4 настай хүүхдийн чихнээс ногоон булаг гараад сар болж байна. Чих өвдөж байна гэж хэлдэггүй, халуурдаггүй, зовиур шаналгаа илэрдэггүй боловч ээж нь үзүүлэхээр авчирсан. Үзлэгээр өвдөлт ба хөхлөг ургацын үрэвслийн шинжгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?
- A. Чихний цочмог халдвар
 - B. Чихний архаг халдвар
 - C. Чихний өвчин байхгүй
 - D. Хөхлөг ургацын үрэвсэл
 - E. Нойтон хульх
- /109./ Хэрлэг төст үений үрэвсэлийн /Ревматоид артрит/ оношлогооны шалгуурт аль шинж ордог вэ?
- A. Том үенүүд өвдөх
 - B. Өглөөний хөшингө 1 цагаас илүү
 - C. Халуурах
 - D. Хорей
 - E. Халдварын анамнезтай байх
- /110./ Сарын тэмдэгийн мөчлөгийн хугацааг яаж тогтоох вэ?
- A. Сарын тэмдэг ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэгийн анхны өдөр хүртэл
 - B. Сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс дараагийн сарын тэмдгийн анхны өдөр хүртэл
 - C. Сарын тэмдэг ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэг дууссан өдрийг хүртэл
 - D. Сарын эхний 5 хоног
 - E. Сарын сүүлийн 5 хоног
- /111./ Цээжний гэмтлийн үед үзүүлэх эмчилгээ, сувилгааг сонгоно уу?
- A. Эмчлүүлэгчийг тайван байлгаж, дулаацуулна
 - B. Өвдөлт намдаах эм хэрэглэнэ
 - C. Зүрхний үйл ажиллагааг дэмжинэ

- D. Цээжийг өндөрлөн, хүчилтөрөгч амьсгалуулна
E. Хавирганы завсраар новокайны хориг хийнэ
- /112./ Сувилгааны үйл ажиллагааны “Үнэлгээний” шатлалын үед сувиллагч юу хийх ёстой вэ?
A. Шийдвэрлэсэн асуудалд үнэлгээ өгөх
B. Тавьсан сувилгааны оношид үнэлгээ өгөх
C. Өвчтөн үзэж үнэлгээ өгөх
D. Сувилгааны төлөвлөгөөний боловсруулалтанд үнэлгээ өгөх
E. Дурдсан үйл ажиллагаа бүгд хамаарна
- /113./ Зүрхний шигдээсээр өвчилсөн хүмүүст аспирын уулгадаг. Аспирин ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?
A. Венийн судсыг тэлэх
B. Тромбин үүсэх үйл явцыг саатуулах
C. Тромбоцитийн агрегацийг багасгах
D. Бүлэн уусгах
E. Зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хэрэгцээг бууруулах
- /114./ Гахай хавдар өвчний үед эрүүний ар хонхор, чихний омогны урд, гавлын хөхлөг ясны орой орчим дарахад эмзэгшилтэй байх нь хэний шинж вэ?
A. Филатовийн
B. Пастийн
C. Мурсугийн
D. Мурсугийн
E. Падалк
- /115./ 38,5 хэмээс дээш халуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?
A. 1\4
B. 1\2
C. 1 бүтнээр
D. 1.5
E. 2 ш-ээр
- /116./ Ходоодны В хэлбэрийн архаг үрэвслийн үндсэн шалтгаан юу вэ?
A. Удамшил
B. Сэтгэл санааны цочрол
C. Хелико бактер
D. Хоолны дэглэм алдагдах
E. Эмийг буруу хэрэглэх
- /117./ Жирэмсний аль үеийн ходлого жирэмсний амь насанд илүү аюултай вэ?
A. Жирэмслэлт бол физиологийн процесс тул амь насанд аюулгүй
B. Жирэмсний эрт үеийн хордлого
C. Жирэмсний хожуу үеийн хордлого
D. Жирэмсний эрт үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
E. Жирэмсний хожуу үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
- /118./ Бүдүүн гэдэсний үүргийг нэрлэнэ үү?
A. Уургийн задрал явагдана
B. Усыг шимэгдүүлнэ
C. Нянгийн нөлөөгөөр ислэг задарч дулаан үүснэ
D. Өтгөнийг ялгаруулна
E. Бүгд
- /119./ Бамбай булчирхайн бүтцийн өөрчлөлтийг илрүүлэх гол шинжилгээг нэрлэнэ үү?
A. Бамбай булчирхайд цацраг идэвхит иодын шингээлт үзэх
B. Термографи
C. Бамбай булчирхайн зураг авах
D. ЭХО
E. Цусан бамбайн даавруудыг тодорхойлох

/120./ Бөөрний гаралтай хавангийн онцлог юу вэ?

- A. Хүйтэн, хатуу, дарахад хонхойно
- B. Улаавтар, хатуу, бүлээн
- C. Цайвар, зөөлөн, дарахад хонхойно
- D. Хатуувтар, хөхөвтөр, дарахад хонхойно.
- E. Зөөлөн, шаравтар, бүлээн

/121./ “Рахиттай” гэж ангилагдсан хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн шахмалаас ямар тунгаар өгөх вэ?

- A. Сард нэг удаа 1 шахмалыг , 2 нас хүртэл
- B. Даваа гариг бүрт 1 удаа 1 шахмалыг 1 сар өгнө
- C. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа 1 шахмалаар , нийт 7 удаа өгнө
- D. Сард нэг удаа 1 шахмалыг 1 жил уулгана
- E. Сард нэг удаа 1 шахмалыг 2 жил уулгана

/122./ 4 настай хүүхэд 4 хоног, өдөрт 5 удаа шингэн суулгасан, баасанд цус байхгүй, орчиндоо хэвийн харьцаатай, хоол ундандаа сайн, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хэвийн арилж байна. ХӨЦМ-ийн дагуу хэрхэн ангилах вэ?

- A. Шингэн алдалтгүй суулгалт
- B. Шингэн алдалттай суулгалт
- C. Шингэн их алдалттай суулгалт
- D. Шингэн алдалтгүй ужиг суулгалт
- E. Шингэн алдалттай ужиг суулгалт

/123./ Чихнээс булаг гарч буй 2 сар хүрээгүй нярайд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг булчинд тариад, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- B. Үүсгэгчийн эсрэг эм уулган, чихийг чихээсээр цэвэрлэн гэрээр эмчилнэ.
- C. Чихэнд ус төрөгчийн хэт исэл дусаан, антибиотиктой уусмалаар угаана
- D. Гидрокортизонтой чихээс чихэнд хийж орхино
- E. Чихийг хөхний сүүгээр угаахыг зөвлөнө

/124./ Зүрхний цочмог шигдээсийн үеийн өвдөлтийн үргэлжлэх хугацааг тодорхойлно уу?

- A. 5 -10 минут
- B. 10-15 минут
- C. 20 мин дээш
- D. 1-2 минут
- E. 3-5 минут

/125./ Зүрхний шигдээсийн үед үзүүлэх анхны тусламжийн зарчим аль нь вэ?

- A. Мэс засал
- B. CPR
- C. Хүчилтөрөгч өгөх
- D. MONA зарчим
- E. Өвдөлт намдаах

/126./ 8 сартай хүүхэд халуурсан, татсан зовиуртай үзүүлэхэд хүүхдийн халуун 38 хэм, таталт намдсан боловч маш их шаналгаатай, чихнээс булаг гойжоод сар болж байгаа. Үзлэгээр чихний ард хүндүүр хавагнасан улайлт байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- A. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний архаг халдвар
- B. Маш хүнд халууралт өвчин. Хөхлөг ургацын үрэвсэл
- C. Халууралт. Чихний архаг халдвар
- D. Халууралт. Чихний цочмог халдвар
- E. Чихний цочмог халдвар

/127./ АД-ын түвшингийн ангилалаар систолын гипертензид аль нь орох вэ? (мм муб)

- A. 160/80
- B. 160/90
- C. 140/90
- D. 140/100
- E. 180/90

/128./ Зүрхний үнхэлцгэнд шингэн хуримтлагдсанаас амьсгаадаж, айдас түгшүүртэй байгаа өвчтөнд ямар эмчилгээ хамгийн чухал вэ?

- A. Эуфиллин
- B. Антибиотик
- C. Сальбутамол
- D. Хатгалт хийж үнхэлцгэнд буй шингэнийг соруулж авах
- E. Панангин

/129./ 38.5 хэмээс дээш халуурч буй 1 нас 5 сартай хүүхдэд парацетамолын 500 мг шахмалыг яаж уулгах вэ?

- A. 1\4-ээр
- B. 1\2-ээр
- C. 1,5-аар
- D. 1 ш-ээр
- E. 2ш-ээр

/130./ Ходоодны шүүсийг шинжлэхэд алийг нь хэрэглэдэг вэ?

- A. Секретин
- B. Холецистокинин
- C. Атропин
- D. Пентгастрин
- E. Магни сульфат

/131./ Зүрхний шигдээсийн үед хамгийн элбэг тохиолддог хүндрэл аль нь вэ?

- A. Зүрхний гаралтай шок
- B. Уушигны хаван
- C. Артерийн даралт ихсэх
- D. Зүрх цусаар чихэлдэх
- E. Тосгуур ховдлын бүрэн хориг үүсэх

/132./ Ходоодны шархлаа гэж сэжиглэсэн үед хийх шинжилгээг нэрлэнэ үү?

- A. Ходоодны шүүсийг шинжлэх
- B. Цусны ийлдэст гастрины түвшинг тодорхойлох
- C. Цөсний хүүдийн зураг авах
- D. Хэвлийн тойм рентген зураг авах
- E. Ходоод дурандах

/133./ Уураг дутагдлын хаван ямар өвчтөнд илүүтэй тохиолдох вэ?

- A. Зүрхний дутагдалтай
- B. Харшилтай
- C. Хүнд тураалтай
- D. Амьсгалын дутагдалтай
- E. Амьсгалын замын халдвартай

/134./ Титэм судас тэлэх үйлчилгээтэй эм аль нь вэ?

- A. Нифедипин
- B. Атеголол
- C. Пропроналол
- D. Нитроглицерин
- E. Аспирин

/135./ Атеросклерозын үүсэл хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү

- A. Амьтны гаралтай өөх тос их хэрэглэх
- B. Давс их хэрэглэх
- C. Эрс тэс уур амьсгал
- D. Байгаль газар зүйн онцлог
- E. Бодисын солилцоо удаан явагдах

/136./ Эмэгтэйчүүдийн ямар өвчнийг арын хүнхрээгээр хатгалт хийж оношлох вэ?

- A. Умайн хүзүүний шархлаа
- B. Умайн хоргүй хавдар

- C. Умайн гадуурхи жирэмслэлт
 - D. Даавруудын цочмог үрэвсэл
 - E. Үргүйдэл
- /137./ Трансляци гэж юу вэ?
- A. ДНХ-ээс уураг үүснэ
 - B. ДНХ-ээс мРНХ үүснэ
 - C. мРНХ-ээс ДНХ үүснэ
 - D. ГФА үүснэ
 - E. мРНХ-ээс уураг үүснэ
- /138./ Долгорын хэвлийн дээд хэсгээр өвдөж, маргааш өглөө хэвлийн ЭХО шинжилгээ хийлгэх болов. Сувилагч ямар зөвлөгөө өгөх вэ?
- A. Ходоод хоосон байх шаардлагатай
 - B. Шинжилгээний дараа ямар нэг эмчилгээ хийх шаардлага гарч магадгүй
 - C. Бага зэрэг юм идэж болно
 - D. Өглөө шинжилгээнд өлөн ирээрэй
 - E. Их юм ууж идэхгүй ирээрэй
- /139./ Гурвалсан мэдрэлийн өвдөлтийн үед тохиолдох боломжгүй шинжийг нэрлэнэ үү?
- A. Эрүү рүү дамжиж өвдөх
 - B. Хатгаж цоргиж, төөнөсөн маягтай хүчтэй өвдөх
 - C. Үе үе дахиж хөдлөх маягаар өвдөх
 - D. Дагз хүзүүний булчин чангарч өвдөх
 - E. Хацар, ам завьж рүү дамжиж өвдөх
- /140./ Төмрийн фолатыг хүнд цус багадалттай эмэгтэйд төрсний болон үр хөндүүлсний дараа яаж уулгах вэ?
- A. Өдөрт хагас шахмалыг уулгана
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш уулгана
 - C. Өдөрт 1 шахмалыг уулгана
 - D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уулгана
 - E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш уулгана
- /141./ Ранитидин ямар эмийн бүлэгт хамаарагдах вэ?
- A. Шүүрэл саармагжуулах
 - B. Гистамины Н-2 рецепторыг саатуулагч
 - C. Ходоодны хөдөлгөөнийг зохицуулагч
 - D. Булчин сулруулагч
 - E. Салстыг нөхөн төлжүүлэгч
- /142./ Сампингийн эрхийн шинжийг хаана тэмтэрч үзэх вэ?
- A. Өвчүүний эрмэгээр
 - B. Хавирганы ясан ба мөгөөрсөн хэсгийн уулзвар дээр
 - C. Суганы дунд шугамаар
 - D. Суганы арын шугамаар
 - E. Өвчүүн дээр
- /143./ 3 настай уушгины хатгалгаатай хүүхдэд амоксициллины 250 мг шахмалаас яаж өгөх вэ?
- A. 1/2-ээр өдөрт 2 удаа 5 хоног
 - B. 1 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
 - C. 1 шахмалаар өдөрт 3 удаа 5 хоног
 - D. 1/4 шахмалаар өдөрт 4 удаа 5 хоног
 - E. 2 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
- /144./ Суулгаж байгаа хүүхдэд товлолын дагуу саагийн вакцин уулгах уу?
- A. Уулгах боловч тунг хийсэнд тооцохгүй, дараа сар нөхөж уулгана
 - B. Дархлаа тогтохгүй учир уулгахгүй
 - C. Уулгаад товлолын дагуу уусанд тооцно
 - D. Уулгахгүй, товлолыг хойшлуулна
 - E. Хэзээ ч уулгахгүй

/145./ Гүйлсэн булчирхайн архаг үрэвслийг цаг тухайд нь эмчлүүлээгүйгээс хүүхдэд ямар өвчнүүд үүсч болох вэ?

А. Хэрэх өвчин, үе мөч, бөөр зүрх судас, бамбай булчирхай, ходоодны архаг үрэвсэл, цус багадалт, судасны цусархаг үрэвсэл, бэлгийн үйл ажиллагааны хямрал

В. Гахайн хавдар, тунгалгийн зангилаанууд томрох

С. Шүд хорхойтох, чихрийн шижин

Д. Зүрх томрох, цус багадалт

Е. Бөөр өвдөнө

/146./ 6 сартай хүүхэд өчигдөрөөс халуурсан, тайван биш болсон зовиуртай, үзүүлэхэд чихнээс булаг гарч байв. Эх нь хүүхдийн чихнээс урд өмнө булаг гарч байсныг анзаараагүй тул хэд хоног гарч байгааг мэдэхгүй. Өөр шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

А. Халууралт. Чихний цочмог халдвар

В. Халууралт. Чихний архаг халдвар

С. Хөхлөг ургацын үрэвсэл

Д. Маш хүнд халууралт өвчин

Е. Чихний архаг халдвар

147./ Зүрхний шигдээсийн үед өвдөлт намдаах зорилгоор ямар эмийг хэрэглэх вэ?

А. Морфин

В. Валидол, нитроглицерин

С. Седуксин

Д. Адерналин

Е. Рибокси

/148./ Цөсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан юу вэ?

А. Удамшил

В. Сэтгэл санааны цочрол

С. Цаг уурын өөрчлөлт

Д. Халдвар

Е. Витамины дутагдал

/149./ Өөх тосны солилцооны өөрчлөлтийг засах эмчилгээнд аль орох вэ?

А. Антиагрегант эм: аспирин

В. Статины бүлгийн эм: симбастатин

С. Антиоксидант: вит Е

Д. АХФС: эналаприл

Е. Нянгийн халдварын эсрэг эм: антибиотик

/150./ 3 сартай зөвхөн хөхөө хөхдөг “Шингэн алдалтгүй суулгалттай” хүүхдэд ямар шингэн уулгахыг зөвлөх вэ?

А. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа шингэлсэн шөл уулгах

В. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа будааны шүүс уулгах.

С. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа тараг, хярам уулгах

Д. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа буцалсан ус, ШСДУ уулгах

Е. Зөвхөн ШСДУ уулгах

/151./ Цөсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан юу вэ?

А. Удамшил

В. Сэтгэл санааны цочрол

С. Цаг уурын өөрчлөлт

Д. Халдвар

Е. Витамины дутагдал

/152./ Зимницкийн сорилоор юу тодорхойлох вэ?

А. 1 минутын диурез, бөөрний түүдгэнцэрийн шүүх ажиллагааг үзнэ.

В. Шингэний ачаалал өгч бөөрний шингэрүүлэлтийн ажиллагааг үзнэ

С. 1 мл шээсээр ялгарч байгаа дүрст элементийг тодорхойлно

Д. 24 цагийн шээсэнд дүрст элементийг тодорхойлно

Е. Бөөрний үйл ажиллагааг үзнэ

/153./ Цэсний хүүдийн цочмог үрэвслийн үед цусны ерөнхий шинжилгээнд гарах өөрчлөлт юу вэ?

- A. Гемоглобин ихсэх
- B. Цагаан эс олшрох
- C. Цусанд сахар багасах
- D. Цусанд сахар ихсэх
- E. Эритроцитын хэмжээ ихсэх

/154./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангиллыг бага эмч ямар шинжийг үндэслэн тавих вэ?

- A. Амьсгал олшрох, ханиалгах
- B. Цээж хонхолзох, ханиалгах
- C. Хяхтнаа амьгал, ханиалгах
- D. Өндөр халуурах
- E. Шуугиантай амьгал

/155./ Нянгаар үүсгэгдсэн цочмог бронхитын үед ямар эмчилгээ хийх вэ?

- A. Антибиотик, сульфаниламид
- B. Халуун бууруулах
- C. Цэр шингэлэх, цэр ховхлох
- D. Гуурсан хоолой өргөсгөх
- E. Судас өргөсгөх

/156./ Цусанд ямар бодис ихэссэнээс арьс салст шарладаг вэ?

- A. Билирубин
- B. Холестрин
- C. Амилаза
- D. Уураг
- E. Сахар

/157./ Зүрх судасны өвчний /ЗСӨ/ нийт эрсдэл гэж юу вэ?

- A. ирэх 10 жилд аминд халгүй, халтай ЗСӨ-өөр өвдөх магадлал
- B. өндөр эрсдэлтэй өвчтөн
- C. ирэх 5 жилд аминд халгүй, халтай ЗСӨ-өөр өвдөх магадлал
- D. Бай эрхтний гэмтэлтэй бол
- E. урьд нь ЗСӨ гэж оношлогдсон

/158./ Ургийн буруу байрлал ямар эмгэгийн үед илүүтэй тохиолдох вэ?

- A. Тулгар жирэмсэн
- B. Жирэмсний хордлого
- C. Төрөх хүчний сулрал
- D. Ихэс түрүүлэлт
- E. Төрөх үеийн цус алдалт

/159./ Зүрхний байрлалыг зөв тодорхойлно уу?

- A. Цээжний хөндийн голд байрлана
- B. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас зүүн тийш 2/3-д байрлана
- C. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас баруун тийш 2/3 -д байрлана
- D. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас зүүн тийш 1/3 -д байрлана
- E. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас баруун тийш 1/3 -д байрлана

/160./ Амьдралын хэв маяг өөрчлөх зөвлөгөөг Артерийн даралт /АД/ ихтэй аль хүмүүст өгөх вэ?

- A. АД-ын түвшингийн ангилалаар гуравдугаар зэрэгтэй бол
- B. АД бууруулах эм уудаг бол
- C. АД бууруулах эмэн эмчилгээ хийлгэдэг эсэхээс үл хамааран бүх өвчтөнд
- D. АГ эхэлж байгаа хүнд
- E. АД хэвийн дээд түвшинд байгаа бол

/161./ Оюуны хомсдолтой хүмүүст аль хандлага нь заавал хэрэгтэй вэ?

- A. Оюун ухааныг сайжруулах эмийн эмчилгээ
- B. Ад шоо үзэхгүй байх

- C. Тусгай сургуульд суралцуулах
 - D. Амьдрах ур чадвар эзэмшүүлэх
 - E. Гэр бүлийнхний асрамжинд байлгах
- /162./ Төмрийн фолатыг хүнд цус багадалттай жирэмсэнд яаж уулгах вэ?
- A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна.
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна.
 - C. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
 - D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уугаад, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна
 - E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна
- /163./ Ревматоидный артритийн үед хэрэглэхгүй эмчилгээг сонгоно уу?
- A. Кортикостеройдоор эмчилнэ
 - B. Индометацин, метиндол
 - C. Алтны бэлдмэл
 - D. Зүрхний гликозид
 - E. Полиартритийн үед үений хөндийд гидрокортизон тарина
- /164./ Хүнд тураалтай хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?
- A. А аминдэм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
 - B. Хооллолтын байдлыг үнэлэн хоолны зөвлөгөө өгнө.
 - C. Фермент эмчилгээ хийж гэрт нь эмчилнэ
 - D. Дексаметазон уулгана.
 - E. Аминдэмээр гэрт нь эмчилнэ
- /165./ Цус багадалттай хүүхдийг хэд хоноод давтан үзэх вэ?
- A. 2 хоноод
 - B. 5 хоноод
 - C. 10 хоноод
 - D. 14 хоноод
 - E. 30 хоноод
- /166./ Өндөр халууралтанд хэдэн хэм орох вэ?
- A. 37,5-38
 - B. 38-38,5
 - C. 38,5-39,5
 - D. 39,5-41
 - E. 41 дээш
- /167./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна. Түүний чихэнд хүрэхэд маш их эмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Хэрхэн ангилах вэ?
- A. Чихний цочмог халдвар
 - B. Хөхлөг ургацын үрэвсэл
 - C. Чихний архаг халдвар
 - D. Аюултай ерөнхий шинжтэй
 - E. Маш хүнд өвчин
- /168./ Артерийн гипертензийн үхэлд хүргэх шалтгаан аль вэ?
- A. Тархинд цус харвах
 - B. Нүдний угт цус харвах
 - C. Бөөрний дутагдал
 - D. Тархины цусан хангамжийн архаг дутагдал
 - E. Зүрхний дутагдал
- /169./ Багтраа өвчний цэр ямар онцлогтой вэ?
- A. Өтгөн ногоон цэр
 - B. Салсархаг шингэн цэр
 - C. Унжралдсан шиллэг цэр
 - D. Цусархаг цэр
 - E. Хөөсөрхөг цэр

/170./ “Шингэн алдалттай суулгалт” гэж ангилагдсан хүүхдэд 4 цагийн турш ямар хэмжээний шингэн уулгах вэ?

- A. 50мл
- B. 100мл
- C. 200 мл
- D. 400 мл
- E. Хүүхдийн биеийн жинг 75 мл-т үржүүлээд гарах хэмжээгээр шингэнийг уулгана.

/171./ Бөмбөрийн цохиур, цагны шилний шинж ямар эмгэгийн үед илрэх вэ?

- A. Гуурсан хоолой тэлэгдэх эмгэг
- B. Гуурсан хоолойн хурц үрэвсэл
- C. Уушигны хурц үрэвсэл
- D. Уушигны сүрьеэ
- E. Гуурсан хоолойн багтраа

/172./ Тархмал хордлогот бахуутай хүний сувилгаанд аль нь хамаарах вэ?

- A. Халуун усанд оруулна.
- B. Хүйтэн усанд оруулна
- C. Гэрэлтүүлэг багатай өрөөнд байлгах
- D. Гичтэй усанд оруулна
- E. Хуурай халуун байранд байлгана

/173./ Элэг цэсийг хэт авиан шинжилгээгээр шинжлэхэд өвчтөнд ямар бэлтгэл хийх вэ?

- A. Өлөн байлгах
- B. Цэвэрлэх бургуй тавих
- C. Давсаг шээстэй байх
- D. Ходоод угаах
- E. Урьд оройноос хоол сойх

/174./ 10 сартай. амьсгал гаргалт шуугиантай байгаа хүүхдэд сальбутамолын 4 мг шахмалыг яаж өгөх вэ?

- A. 1\2-ээр өдөрт 3 удаа
- B. 1\2-ээр өдөрт 4 удаа
- C. 1\4-ээр өдөрт 3 удаа
- D. 1\4-ээр өдөрт 4 удаа
- E. 1 шахмалаар 1 удаа

/175./ Гүйлсэн булчирхайн цочмог үрэвсэл халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

- A. Биеэр түгээмэл улаан тууралт шатлаж гарна
- B. Цустай суулгана
- C. Дагзны булчин хөшингө шинж илэрнэ
- D. Гүйлсэн булчирхай улайж, хөөнгөтөж, идээлсэн байна
- E. Ханиах, нус гойжих шинж илэрнэ

/176./ Архаг гепатитын үед аль шинж түгээмэл илрэх вэ?

- A. Элэгний үйл ажиллагааны дутагдал
- B. Өвдөлтийн хам шинж
- C. Боловсруулалтын хямралын хам шинж
- D. Мэдрэл сульдлын хам шинж
- E. Цусархаг хам шинж

/177./ Багтраа өвчний цэр ямар онцлогтой вэ?

- A. Өтгөн ногоон цэр
- B. Салсархаг шингэн цэр
- C. Унжралдсан, шиллэг цэр
- D. Цусархаг цэр
- E. Хөөсөрхөг цэр

/178./ Тархины судасны атеросклероз болоход эмнэлзүйд ямар шинж илрэх вэ

- A. Цээжээр өвдөх

- B. Толгой өвдөх
- C. Дотор муухайрах
- D. Хөл чинэрч өвдөх
- E. Артерийн даралт ихсэх

/179./ Хүүхэд нярайлах хугацааг яаж тогтоох вэ?

- A. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс 3 сарыг хасч, 15 хоног нэмнэ.
- B. Сүүлийн сарын тэмдэг ирсэн эцсийн өдрөөс 3 сарыг хасч, 15 хоног нэмнэ.
- C. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс 3 сарыг хасч, 7 хоног нэмнэ
- D. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдөр дээр 9 сарыг нэмнэ
- E. Сүүлийн сарын тэмдэг ирсэн эцсийн өдөр дээр 10 сарыг нэмнэ.

/180./ Нугасны шингэн хаана агуулагддаг вэ?

- A. Хатуу бүрхүүл, ясны эд хоёрын хооронд
- B. Хатуу бүрхүүл, судсан бүрхүүл хоёрын хооронд
- C. Нугасны дотор талаар
- D. Нугасны гадна талаар
- E. Нугасны гадна ба дотор талаар

/181./ Элэгний үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

- 1. Хурц биш атлаа унжих, цанхайх маягаар өвдөх
- 2. Элэг томрох шинж тэмтрэлтээр илрэх
- 3. Өвдөлт баруун мөр, гар руу дамжих
- 4. Өвдөлт доошоо цавь, хярзан руу дамжих
- 5. Өвдөлт зүүн мөр, гар руу дамжих

/182./ Венийн судсанд тарилга хийх үед юуг анхаарах ёстой вэ?

- 1. Судсаар хольж болохгүй тарилгуудыг
- 2. Тарих эмийн нэр хаяг, хадгалах хугацаа, тун хэмжээ
- 3. Тарих талбай хатгах судсыг зөв сонгох
- 4. Тариурын зүү судсанд байгаа эсэхийг шалгах
- 5. Тарилгыг аажим болгоомжтой шахах

/183./ Балнад өвчний үед ямар эмнэлзүйн шинжүүд илэрч болох вэ?

- 1. Бие сульдах, толгой өвдөх, шингэн баах, хоолны дуршилгүй болох
- 2. Өвчний ид үед халуун 39-40 хэм хүрч, халуун өдөр бүр давшингүй нэмэгдэх, ухаан балартаж, дэмийрэх
- 3. Өвчний 8-10 дахь хоногт арьсан дээр цөөн тооны ягаан тууралт гарна
- 4. Биеэр цэврүүтэй олон тооны тууралт гарна
- 5. Хоёр хөлний шагай, өвдөгөөр жижиг цэгчилсэн цусан тууралт жигд гарна

/184./ Шингэн их алдалттай суулгалтын шинжүүдийг заа:

- 1. Унтаарсан, ухаангүй, ууж чадахгүй
- 2. Нүд хонхойх
- 3. Арьсны хуниас маш удаан буюу 2 секундээс удаан арилах
- 4. Тайван биш, цочромтгой
- 5. Цангасан, ховдоглон уух

/185./ Тэмбүүтэй эмэгтэйд ямар эмчилгээ хийх вэ?

- 1. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух
- 2. Бензатилпенициллин G 2,6 саяар тарина
- 3. Цефтриаксон 250 мг булчинд 1 удаа тарих
- 4. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух,
- 5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух.

/186./ 38 долоо хоногтой жирэмсэн эхэд төрөх үйл ажиллагааны тухай бага эмч ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?

- 1. Төрөлтийн үйл ажиллагаа товлосон хугацаанаас 14 хоногийн наана, эсвэл 7 хоногийн цаана эхэлж болно

2. Төрөхөөс өмнө салиархаг зүйл үтрээнээс гарч болно
 3. Гэдэс дуншиж өвдөх нь эхлээд хэдэн цагийн зайтай байснаа хоорондох зай нь ойртох болно. Энэ нь төрөх үйл ажиллагаа эхэлсэн шинж
 4. Дуншиж өвдөсний дараа хүчтэй базлуулж, дүлүүлж өвдөнө
 5. Төрөх үйл ажиллагаа эхэлмэгц төрөх газар очих хэрэгтэй
- /187./ Хавантай өвчтөнд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Хоолонд давс хязгаарлах ба харшил үүсгэдэг хүнсний бүтээгдэхүүнийг хориглоно
 2. Хаван хөөх зорилгоор шээс хөөх эм хэрэглэнэ
 3. Шалтгааныг тогтоож, шалтгааны ба эмгэг жамын эсрэг эмчилгээ хийнэ, үр дүн өгөхгүй бол эмнэлэгт хэвтүүлнэ
 4. Физиологийн уусмал дуслар хийнэ
 5. Реополиглюкин эсвэл полиглюкин дуслар хийнэ
- /188./ Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар эмүүд зайлшгүй шаардлагатай вэ?
1. Окситоцин, эргометрин
 2. Магнийн сульфат, диазепам
 3. Кальцийн глюконат
 4. Ампициллин, Гентамицин, Метронидазол
 5. Рингерийн лактат
- /189./ Бөөрний архаг дутагдлын үед зайлшгүй хийгдэх шинжилгээ юу вэ?
1. Шээсний нянгийн шинжилгээ
 2. Цусны электролитыг үзэх
 3. Цусны PH үзэх
 4. Цусан дахь креатинины хэмжээг тодорхойлох
 5. Бөөрний рентген зураг авах
- /190./ Ямар хүүхдийн хооллолтыг үнэлэх ёстой вэ?
1. Цус багадалттай хүүхдийн
 2. Тураалтай хүүхдийн
 3. Тураалгүй, цус багадалтгүй ч 2 хүртэлх насны бүх хүүхдүүдийн
 4. 1-5 хүртэлх насны бүх хүүхдүүдийн
 5. Рахиттай хүүхдийн
- /191./ Хүүхдэд цээж хонхолзох шинж илэрч байвал бага эмч ямар арга хэмжээ авах вэ?
1. Гараа эмчилгээнд үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг уулгана
 2. Гараа эмчилгээнд цусны сахар багсахаас сэргийлнэ
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Утлага хийж гэрээр эмчлэнэ.
 5. Хөлийг гичтэй усанд дүрж гэрээр эмчилнэ
- /192./ Бэлгэвч хэрэглэхийн сул тал юу вэ?
1. Резинд харшил үүсч болно
 2. Бэлгийн хавьтлын үед бэлгэвч мултрах, урагдах эрсдэлтэй
 3. Бэлгийн дур буурч болно
 4. Бага аарцгийн үүрэвсэл үүсгэж болзошгүй
 5. Үргүйдэл, умайн гаднах жирэмслэлт үүсч болзошгүй
- /193./ 20 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт.
 2. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол
 3. Зулбалтаас сэргийлэх тухай
 4. Төрөлтийн тухай
 5. Жирэмсний эмзэг байдлын тухай
- /194./ Цусан суулгалт өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Хошноогоороо шээж буй мэт их хэмжээний усархаг шингэнээр суулгах
 2. Хий дүлүүлэлттэй, бага хэмжээтэй, ойрхон уйланхай, цустай суулгах
 3. Намгийн замгаг шиг ногоон язмагтай, усархаг зүйлээр суулгах

4. Хэвлийн доод хэсгээр базлуулж өвдөх
 5. Хараар суулгах
- /195./ Өрхийн сувилагч нар хүн амаа эрүүл мэндийн байдлаар хэдэн бүлэг болгон хуваадаг вэ
1. Цоо эрүүл
 2. Эрүүл
 3. Ээнэгшил бүхий архаг өвчтэй
 4. Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй
 5. Ээнэгшлээ алдсан архаг өвчтэй
- /196./ Сэтгэл гутралтай өвчтөнг ямар тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэх заалттай вэ?
1. Амиа хорлох буюу үхэх бодолтой
 2. Амиа хорлох тусгай төлөвлөгөөтэй
 3. Өнгөрсөн хугацаанд амиа хорлох ноцтой оролдлого хийж байсан
 4. Бусдын амь насанд хор хохирол учруулах бодолтой
 5. Хүнд хэлбэрийн сэтгэл гутрал
- /197./ Хүүхдэд улаанбурханы ямар шинжүүдийг ажиглах ёстой вэ?
1. Түгээмэл тууралт
 2. Ханиалга.
 3. Нус гойжих
 4. Нүд улайх
 5. Халуурах.
- /198./ Удаан хугацаагаар хэрэглэвэл дасал шунал үүсгэдэг эмийг сонгоно уу.
1. Доктор мом
 2. Тусупрекс
 3. Либексин
 4. Кодеин
 5. Бронхоцин
- /199./ Физиологийн гаралтай биений юмгүйдэл хэзээ ажигладдаг вэ?
1. Хүүхэд насанд
 2. Жирэмсэн үед
 3. Цэвэршсэн эмэгтэйд
 4. Хөхүүл байх бүх хугацаанд
 5. Төрсний дараа 2 жил
- /200./ Тууралт үндсэн шинж нь болдог өвчнүүдийг дурьд:
1. Сахуу
 2. Улаан бурхан
 3. Татран
 4. Улаан эсэргэнэ
 5. Хумхаа

Сорилын зөв хариулт

1-A, 2-A, 3-E, 4-A, 5-A, 6-E, 7-A, 8-E, 9-A, 10-C, 11-B, 12-A, 13-C, 14-E, 15-A, 16-A, 17-E, 18-E, 19-E, 20-A, 21-B, 22-E, 23-A, 24-C, 25-E, 26-E, 27-A, 28-E, 29-C, 30-A, 31-B, 32-B, 33-A, 34-A, 35-E, 36-A, 37-A, 38-C, 39-C, 40-A, 41-D, 42-A, 43-C, 44-E, 45-E, 46-A, 47-E, 48-E, 49-A, 50-E, 51-A, 52-E, 53-A, 54-A, 55-E, 56-C, 57-D, 58-E, 59-C, 60-A, 61-A, 62-B, 63-A, 64-E, 65-B, 66-A, 67-E, 68-E, 69-E, 70-E, 71-B, 72-D, 73-E, 74-C, 75-A, 76-A, 77-C, 78-C, 79-A, 80-A, 81-A, 82-E, 83-A, 84-C, 85-E, 86-E, 87-E, 88-A, 89-E, 90-E, 91-A, 92-E, 93-E, 94-A, 95-A, 96-C, 97-A, 98-E, 99-B, 100-B, 101-C, 102-D, 103-A, 104-B, 105-A, 106-C, 107-A, 108-B, 109-B, 110-B, 111-E, 112-C, 113-C, 114-A, 115-C, 116-C, 117-C, 118-E, 119-D, 120-C, 121-C, 122-A, 123-A, 124-C, 125-D, 126-B, 127-A, 128-D, 129-A, 130-D, 131-A, 132-E, 133-C, 134-D, 135-B, 136-C, 137-E, 138-D, 139-D, 140-D, 141-B, 142-B, 143-C, 144-A, 145-A, 146-A, 147-A, 148-D, 149-B, 150-D, 151-D, 152-E, 153-B, 154-A, 155-A, 156-A, 157-A, 158-D, 159-B, 160-C, 161-D, 162-D, 163-D, 164-A, 165-D, 166-D, 167-A, 168-A, 169-C, 170-E, 171-A, 172-C, 173-A, 174-D, 175-D, 176-D, 177-C, 178-B, 179-C, 180-D, 181-A, 182-E, 183-A, 184-A, 185-C, 186-E, 187-A, 188-E, 189-C, 190-A, 191-A, 192-A, 193-A, 194-C, 195-E, 196-E, 197-E, 198-D, 199-A, 200-C,